



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 2/590

Хэрлэн сум

“Талын гөрөөчин тайга нохой-2023”
эвент арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Хорьдугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Монголчуудын эртнээс уламжлагдан ирсэн анч тайга нохойгоор гөрөөлөх өв соёлыг уламжлан авч үлдэх, түгээн дэлгэрүүлэх, тайга нохойн ахуй соёл, зан зашлыг олон улсын хэмжээнд таниулах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг хөгжүүлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Талын гөрөөчин тайга нохой-2023” эвент арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны..... дугаар сарын.....-ны
..... дугаар захирамжийн хавсралт

**“ТАЛЫН ГӨРӨӨЧИН ТАЙГА НОХОЙ-2023” ЭВЕНТ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зохион байгуулах арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгж дүн /сая төгрөг/	Нийт дүн /сая төгрөг/
1	Зар сурталчилгаа, хэвлэл мэдээллийн гэрээт үйлчилгээ	1	3,000,000	3,000,000
	НИЙТ ДҮН			3,000,000